



ГҮНДИЙН БАГАА

Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн бага хурлын тэргүүлэгчдийн дарга
1944-1956 он

Хуучин Тушээт хан аймаг, Дэлгэрхангай уулын хошуу одоогийн Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт төржээ. Найман нас хүртэл эхийн асрамжид гэртээ өсөж 15 нас хүртэл бусдад зарцлагдаж, монгол бичиг бие даан сурч

1931 онд Улаанбаатар хотод соёлын довтолгооны багш бэлтгэх нэг жилийн курс, 1935-1936 онд ЗХУ-д дотоод яамны нэг жилийн курс, 1940-1944 онд ЗХУ-д Дорно дахины дээд сургууль, 1956-1959 онд коммунист намын дээд сургуульд тус тус суралцан төгссөн. 1932-1933 онд Хөвсгөл аймгийн Ар-жаргалант суманд соёлын довтолгооны багш, 1933-1940 онд Дотоодыг хамгаалах газар төлөөлөгч, тасгийн дарга.

1944-1956 онд Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дарга, 1959-1963 онд Хөвсгөл аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, 1963-1968 онд БНМАУ-аас БНКУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, 1966-1968 онд БНХАУ-д БНМАУ-ын Элчин сайдын яамны элчин зөвлөх, 1968-1969 онд БНМАУ-ын СнЗ-д зохион байгуулагч, 1969-1974 онд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох суманд сум, нэгдлийн даргаар ажиллаж байгаад нас баржээ.

Нам улсад 40 гаруй жил үр бүтээлтэй ажиллаж, МАХН-ын 11, 12, 13, 14 дүгээр их хуралд төлөөлөгчөөр оролцож, Намын Төв Хорооны орлогч гишүүн, Улсын бага хурлын гишүүнээр мөн БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатаар дөрвөн удаа, аймаг хотын ардын хурлын депутатаар удаа дараа сонгогдож байжээ.

Г.Багаагийн амжилт бүтээлийг үнэлж "Сүхбаатарын одон", "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор хоёр удаа, "Алтан гадас" болон бусад одон медалиудаар шагнажээ. Хотын захиргааны даргаар 12 жил ажиллахдаа улсынхаа нийслэлийг хөгжүүлэх, хүн амын үйлчилгээ соёлыг дээшлүүлэх талаар их зүйлийг хийж бүтээсэн юм.

1950-иад онд хотыг барьж байгуулах, тохижуулах, хүн амын төрөл бүрийн үйлчилгээг өргөтгөх ажил хот даяар эрчимтэй өрнөж Улаанбаатар хотыг хөгжүүлэх анхны ерөнхий төлөвлөгөөг 1954 онд зохиожээ.

Засгийн газрын ордны эхний ээлж, улсын Дуурь Бүжгийн Академик театрын барилга 1950-1951 онд ашиглалтад орж орон сууцны нэгдүгээр дөчин мянгатын хорооллын барилга, Гадаад яам, "Элдэв-Очир" кино театр, "Алтай" зочид буудал (одоогийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар) Сүхбаатарын талбай зэрэг төвийн гол барилга байгууламж хот тохижилтын ажил энэ хугацаанд ид хийгдэж байсан юм.

Зөвхөн 1950 онд Намын Төв Хорооны арын гудамж талбай, Төв больниц, Холбооны яамны орчны гудамж, зам талбайн 40.0 мянган шоо метр газрыг тэгшилж явган хүний зам, 25.0 мянган шоо метр талбайг асфальталж 3000 мод шинээр тарьж, 700-аад модонд хайс хамгаалалт хийж 11 гудамжийг бүрэн тохижуулсан байна. Хотын үйлдвэрийн газрууд 1950 онд 107.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдааны газрууд 33 дэлгүүр, 40 мухлагаар 47.1 сая төгрөгийн өргөн хэрэгцээний бараа борлуулж байжээ. 1950 онд хотод 62.6 мянган хүн оршин сууж байсны дотор хотын харьяат хүн ам 55.5 мянга байжээ. Есөн бага сургууль, зургаан бүрэн, бүрэн бус дунд сургуульд 5.7 мянган сурагч, 23 цэцэрлэгт 1.2 мянган хүүхэд хүмүүжиж байв. Энэ үед хотын хүн амыг бичиг үсэгт сургах ажил бүх нийтийг хамарсан кампанит ажил болон явагдаж, 285 бүлгэмд 8.0 мянган хүнийг шинээр, 3.2 мянган хүнийг давтан сургажээ.

1950 онд хотод хүний их эмчийн салбар зургаа, больниц зургаа, эмчилгээний нийт ор 180 байснаас гадна гэртээ радиотой айл 4774, цахилгаан гэрэл тавьсан айл 13.0 мянга, хотын хүн тээвэрт шугамын автобус долоо, ачааны ба суудлын такси тус бүр гурав үйлчилж байсан нь тэр үедээ ахицтай үзүүлэлт байсан боловч нийслэлийн өнөөгийн байдалтай харьцуулахад өчүүхэн хэсгийг эзлэх бөгөөд энэ завсар нийслэл хотын байдал хүн амын үйлчилгээ, соёл боловсролын түвшин үлэмж хөгжиж өөрчлөгдсөнийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй үүрэг гүйцэтгэсэн хүн юм.